



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

# 2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

*Өврийн дэвтэр*



Улаанбаатар хот  
2021 он

# **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН ТОГТООЛЫН**

- **Нэгдүгээр хавсралтаар:**  
“Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг
- **Хоёрдугаар хавсралтаар:**  
“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг
- **Гуравдугаар хавсралтаар:**  
“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг
- **Дөрөвдүгээр хавсралтаар:**  
“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг
- **Тавдугаар хавсралтаар:**  
“Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг тус тус баталсан

**2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ**

• **ХӨТӨЛБӨРҮҮД** •

# ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### ● ЗОРИЛГО ●

Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах

### ● ХАМРАХ ХҮРЭЭ ●

- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн;
- Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд;
- Хорих ангиас суллагдсан иргэн;
- Асрамжийн газраас гарсан иргэн;
- 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн;

### ● АРГА ХЭМЖЭЭ ●

- Хөдөлмөрт бэлтгэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
- Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг шалгаруулах;

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ АРГА ХЭМЖЭЭГ

## • ЗОХИОН БАЙГУУЛАХ •

### НЭГДҮГЭЭРТ 1

Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах хүрээнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.

### ХОЁРДУГАРТ 2

Хувь хүний төлөвшил, сэтгэлгээг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэхийн ач холбогдол болон түүний харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны мэдлэг олгох хүрээнд ажлын байран дахь харилцааны ур чадвар, сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулна.

### ГҮРЭВДҮГЭЭРТ 3

Иргэнийг ажилд зуучлахад нэн шаардлагатай ахуйн хэрэглээний тусламж, дэмжлэгийг үзүүлэх хүрээнд ажилд зуучлахад бэлтгэнэ.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ

## • ЗОХИОН БАЙГУУЛАХ •



Мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтыг зохион байгуулна.

Мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулна.

- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын нийт 60 хувиас багагүй 2.1-т заасан /Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн/
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэнд “Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв зохион байгуулж, Чадамжийн гэрчилгээ олгох ба иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамрагдаж болно.

**2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ**

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### • ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ •

#### 1 САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох,  
Fintech,  
ААЭ-ийн сургалт

#### 2 МАЛЧДЫГ МАЛЖУУЛАХ

Малчин өрх,  
Гэрээт малчин өрхийн санхүүгийн  
дэмжлэг,  
Мал маллах арга ухааны сургалт

#### 3 БОРЛУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Борлуулалтын цэг, Худалдааны цахим  
хуудас

#### 4 АЖИЛ ОЛГОГЧИЙГ ДЭМЖИХ

Ажил олоход хүндрэлтэй иргэн,  
ААНБ

#### 5 НИЙТИЙГ ХАМАРСАН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Түр ажлын байр бий болгох.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### ● САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ●

#### 1 АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ

Батлагдсан хөтөлбөрүүдийн СД арга хэмжээ болон төсөл өгсөн, төсөл нь шалгарсан иргэн,

ХХЭИргэн

Ажлын 3 хоног, 21+ цаг

Эрх бүхий СБ (5/18)

Туршлага солилцох уулзалт,

хэлэлцүүлэг 5% хүртэл

#### БОГИНО ХУГАЦААНЫ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ ОЛГОХ 2

Fintech: Эргэн төлөгдөх нөхцөлтэй, 1 сар хүртэлх хугацаатай, 150-500Т мянга, Шимтгэлийг зээлдэгч хариуцах

#### ИРГЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ 3

- Аж ахуй, бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ (худалдаа биш) эрхлэх хүсэлтэй, 35+ настай
- ХХЭиргэн, Гадаад улсад ХЭ байгаад ирсэн иргэн
- 5.0Т хүртэл сая, 36 сар, 100% эргэн төлөгдөх нөхцөлтэй 2 үе шаттай зохион байгуулна. (Төсөл, Эргэн ТХ + Амжилттай хэрэгжих нөөц боломж)
- ХЭДС-аас олгох бусад СД-тэй давхардуулахгүй

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### ГЭРЭЭТ МАЛЧИН ӨРХИЙГ АЖИЛД ЗУУЧЛАХ

Гэрээт малчин нь

- УБ хотод 1жил оршин суусан, гэрээт малчнаар ажилд зуучлагдах хүсэлтэй /2 жил/ 18-59 насны 2-оос доошгүй гишүүнтэй байх

Ажиллуулах малчин нь

- 600+ толгой малтай байх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах /мөнгөн хэлбэр/
- Ажил олгогч малчин болон гэрээт малчин өрхийн гишүүнд Н/ДШ+Нүүх суух зардал (орон нутаг руу)



2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

ГЭРЭЭТ МАЛЧИН ӨРХӨД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ



ГЭРЭЭТ МАЛЧИН ӨРХИЙН ХҮСЭЛТЭЭР ГЭРЭЭТ МАЛЧНААР 2 ЖИЛ ХҮРТЭЛ ТОГТВОРТОЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛТЭЙ ГӨӨР САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОНО.



3.0₮ сая,  
мал  
худалдан  
авах



• Эргэн  
төлөгдөх  
нөхцөлтэй,  
гэрээ



• 36 сарын  
хугацаанд,  
эргэн  
төлөгдөх

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар удирдлага арга зүй зохицуулалтаар хангаж ажиллах ба аймаг, дүүргийн ХХҮТ, Хэлтэстэй хамтран зохион байгуулна.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### ● БОРЛУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ●

ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэдэд бараа бүтээгдэхүүнээ борлуулахад нь дэмжлэг үзүүлэх;

#### БОРЛУУЛАЛТЫН ЦЭГ

- Аймаг, дүүргийн ХХҮГ, Хэлтэс иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах цэгийг ажиллуулна.
- Үзэсгэлэн яармаг зохион байгуулж дэмжлэг үзүүлнэ.
- Түрээсийн төлбөр, урсгал зардал гаргана.

#### ЦАХИМ ХУДАЛДААНЫ САЙТ

- ХХҮЕГ нь худалдааны цахим хуудсыг бий болгож, хөгжүүлнэ.
- Цахим хуудсыг нээснээр иргэдийг үнэ төлбөргүй дэмжлэг үзүүлнэ.

**2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ**

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### ● АЖИЛ ОЛГОГЧИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ ●

Ажил олоход хүндрэлтэй иргэнийг авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлыг нөхөн төлөх, тухайн иргэнийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх.



- Ажил идэвхитэй хайж байгаа боловч 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг 12 сараас дээш хугацаагаар ажлын байраар хангаж, цалин хөлс олгож, НД-т хамруулсан ажил олгогчид 1 удаа (ХХДХэмжээг\*12) урамшуулал.

- Үйлдвэрлэл дээр дадлагажуулан ажлын байраар хангаж, 12 + сар ажлын байраар хангаж, үргэлжлүүлэн тогтвортой ажиллуулж байгаа бол (Сургалтын зардал+1 жилийн цалин) дэмжлэг болгон өгнө.

## 2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

### • ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

## • ХӨТӨЛБӨР •

### НИЙТИЙГ ХАМАРСАН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ, Хэлтэс төслийг хүлээн авч бий болох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо зэргийг хянан үзэж хамтран ажиллах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна.

- Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс: Хор уршгийг арилгах, нөхөн сэргээх

- Нийтийн эзэмшлийн зам, гудамж талбайд бүтээн байгуулалт, тохижилт хийх

- Байгаль орчныг хамгаалах: ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах

- Хуваарилсан нийт хөрөнгийн 10-15% хог хаягдал цэвэрлэхэд зарцуулах.

- Орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран иргэдийг түр ажлын байраар хангах ба (10 хүртэл хоногоор, 8 хүртэл цагаар тооцно.)

- НЗБ, ААНБ-ын хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүргийг нийтийг хамарсан ажлаар гүйцэтгүүлэхгүй.

- Цалинн урамшууллаас НДШ тооцохгүй.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

• ХӨТӨЛБӨР •

● ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН ●

## АРГА ХЭМЖЭЭ ТУС БҮРЭЭР:

- Хамрагдсан хүний тоо
- Зарцуулсан хөрөнгийн хэмжээ
- Санхүүгийн дэмжлэгийн хувьд дэд арга хэмжээ бүрээр Эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ

## ХҮРЭХ ҮР ДҮН:

- Арга хэмжээ бүр дээр чанарын үзүүлэлтээр үр дүн тооцох (харьцуулалт)
- Тодорхой арга хэмжээнүүд дээр тоон үзүүлэлтээр үр дүнг давхар тооцох



2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ

## • ТӨСӨЛ •

### ЗОРИЛГО

- Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, аж ахуй эрхлэх бүтээлч шинэлэг санаачлагыг дэмжих

### ХАМРАХ ХҮРЭЭ

- 15- 34 насны ажилгүй ажил хийхэд бэлэн, ажил идэвхитэй хайж буй залуучууд
- Их ДС МБСБ төгсөөд 3 хүртэл жил болж байгаа залуучууд

### АРГА ХЭМЖЭЭ

- Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх
- Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх
- Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох



2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ

## • ТӨСӨЛ •

### ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

- Залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийж АМЧБОЗӨ үйлчилгээ үзүүлнэ.
- Залуучуудыг тохирох ажлын байранд зуучлах

### ШИЛДЭГ “СТАРТ-АП” ЗАЛУУЧУУДАД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

- Дүүрэг бүрт төслийг шалгаруулж 10 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
- Шалгарсан төсөл Улсын хэмжээнд оролцоно. Улсын



2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

### ЗОРИЛГО

● Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллах, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлан ажлын байр бий болгох, ажил олгогчийг дэмжих болон тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар тэднийг байнгын ажлын байраар хангахад оршино.

### ХАМРАХ ХҮРЭЭ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагууд

### АРГА ХЭМЖЭЭ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх
- Санхүүгийн дэмжлэг олгох
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх
- Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙГ ХӨДӨЛМӨРИЙН НЭЭЛТЭЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИЛЛАХАД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

- Ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулагдана
- Үргэлжлэх хугацаа 14-21 хоног хүртэл байна
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн жилд 1 удаа хамрагдана
- Тохирох ажлын байрны талаар мэдээллийг цуглуулж, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, жагсаалт гаргана.
- Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багшийг бэлтгэх сургалтыг мэргэжлийн байгуулагатай гэрээ байгуулна



- Ажлын байран дахь ажиллах орчин, нөхцөл, ажлын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд ХБИ-ний онцлогт нийцүүлэн хэрэгцээт тохируулгыг хийж шаардлагатай бол хувийн туслах, ажлын байран дахь дадлагажуулагчийн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлэх.
- Хамт олны хандлага өөрчлөх сургалт зохион байгуулна.
- Ажиллах явцад учирч олзлогүй бэрхшээлийг даван туулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

### ИРГЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхэлж ажлын байр бий болгох зорилготой хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхийн төслийг сонгон шалгаруулж 3.0-5.0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаанд 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэй олгоно.

### ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

ХБИ-ний онцлогт нийцүүлсэн тусгайлсан ажлын байр бий болгож, тогтвортой ажиллуулах хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төслийг шалгаруулж, 1 ажлын байрыг 5.0 сая төгрөгөөр тооцон барьцаагүй, хүүгүй, 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлгүй олгоно.

### АЖ АХУЙН НЭГЖИД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

ХБИ-ний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь ХБИ-тэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, шинээр тохируулгатай ажлын байр бий болгох тухай, мөн аж ахуйн нэгжийн ХБИ-ийг тохируулгатай ажлын байранд тогтвортой ажиллуулах тухай боловсруулсан төслийг шалгаруулж, 1 ажлын байрыг 5.0 сая төгрөгөөр тооцон барьцаагүй, хүүгүй, 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр 36 сарын хугацаатай олгоно.

**2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ**

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

### САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

#### Ажлын байр хадгалах дэмжлэг үзүүлэх

● ХБИ-ний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь ХБИ-тэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн ХБИ-ний ажилладаг ажлын байрыг цар тахлын үед хадгалж, хамгаалахад зориулж, УОК-ын шийдвэрээр үйл ажиллагааг нь хягаарласан хоног бүрээр тооцож, ажлын байр хадгалах дэмжлэгийг олгоно.

#### Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах

- Хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж,
- Хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулалтын дэмжлэг үзүүлнэ.



2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

Ажил олгогчид  
дэмжлэг  
үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүдсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулыг нэг удаа олгоно.

25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор тус тус нэг удаа олгоно.

Ажлын байрны  
түрээсийн төлбөрт  
дэмжлэг  
үзүүлэх

Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны 1-6 дугаар сарыг дуустал хугацааны ажлын байрны түрээсийн төлбөрт “Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ”-гээр тооцож нэг удаагийн мөнгөн дэмжлэгийг сар бүр нөхөн олгоно.

## 2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

### • ХӨТӨЛБӨРҮҮД •

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

• ХӨТӨЛБӨР •

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн ур чадвар, чадамжийг 1-10 сарын хугацаанд багтаан эрх бүхий мэргэшсэн боломжит тохирууллагатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллага иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд уг сургалт нь модуль хэлбэртэй тусгайлсан сургалтын хөтөлбөрт суурилсан байна.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

### Хөтөлбөрийн зорилго

Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

### Хамрах хүрээ

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахмад мэргэжилтнүүд  
- Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод  
- Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан

### Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах  
- Ахмадын төрийн бус байгууллагуудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах  
- Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •

### АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, төслийг сонгон шалгаруулна.

Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйл ажиллагаа шаардлагатай байгаа төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд /урилга, мэдээлэл, төсөл ирүүлнэ/

Хамрагдсан ахмадад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишиг хэмжээгээр ажилласан цагийн урамшууллыг тооцож, төсөлд хамрагдсан байгууллагын ирүүлсэн тайлан, ажлын цагийн бүртгэлд үндэслэн урамшууллыг ахмад мэргэжилтэнд шууд олгох ба нийтийг хамарсан ажил зохион байгуулах журмын дагуу НДШ төлөхгүй

Зөвлөх мэргэжилтний төслийн хүрээнд олгох урамшууллыг тооцохдоо нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байхыг төсөл, холбогдох гэрээнд тусган ажиллана.

Төсөлд хамрагдаж буй ахмад мэргэжилтэн өөрийн эзэмшсэн ур чадвар, туршлагад үндэслэн төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн салбаруудаас давхардуулахгүй сонгож зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •



### АХМАДЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг ахмадын эрх ашгийг хамгаалсан холбоод нь бүтээн байгуулалт болон бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
- Зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх ахмад настны эрх ашгийг хамгаалах холбоо тухайн зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэх мэргэжлийн өндөр, ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байна.



2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •

# АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ

## • ХӨТӨЛБӨР •



Аж ахуй, өрхийн  
үйлдвэрлэл эрхлэхэд  
зориулан эргэн төлөгдөх  
нөхцөлтэй санхүүгийн  
дэмжлэг олгох



Ахмадуудад 3.0 сая хүртэл  
төгрөгийн санхүүгийн  
дэмжлэгийг 24 сарын  
дотор 100% эргэн төлөх  
нөхцөлтэй олгоно.

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •







ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ,  
5-Р ХОРОО, ДХАВГАСҮРЭНГИЙН  
ГУДАМЖ 38, ХЭЛТСИЙН БАЙР



7708-1220



[info@bayanzurh.hudulmur-halamj.gov.mn](mailto:info@bayanzurh.hudulmur-halamj.gov.mn)



<http://bayanzurh.hudulmur-halamj.gov.mn/>

2021-2022 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ

• ХӨТӨЛБӨРҮҮД •